



МОНГОЛ УЛС  
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/С85

Зуунмод

Газар эзэмших эрхийг баталгаажуулж,  
зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төв аймгийн Зуунмод сумын Номт 1-р баг, Соёмбо хотхон, Д.Бодоогийн гудамж 200 тоотод Төв аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо /8092702/-ны нам, олон нийтийн байгууллагын зориулалтаар эзэмшиж буй 1020м<sup>2</sup> газрын зориулалтыг оффис, орон сууц болгон өөрчилж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Төв аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоо /Д.Оюун/-д дараах үүргийг хариуцуулсугай.

2.1 Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2 Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах


2.3 Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх

2.4 Оффис, орон сууцны барилга баригдаж дууссаны дараа эзэмшиж буй газрыг нийтийн эдэлбэрт шилжүүлэх

3.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, оффис, орон сууцны барилга баригдаж улсын комисс хүлээн авсны дараа нийтийн эдэлбэрт шилжүүлэхийг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 314 дүгээр захирамж болон газар эзэмших эрхийн 6271 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 01706